# УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 12 Улаанбаатар хот

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь хүний нөөцийн нээлттэй, ил тод зарчмыг үйл ажиллагаандаа баримталж ажилладаг. УНТЭ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020.06.30-ны өдрийн 11 тоот тогтоолоор **"УНТЭ-ийн удирдах ажилтан, ажилтан сонгон шалгаруулах"** журмыг батлуулж мөрдөн ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 86 дугаар тогтоолоор "Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам" батлагдсантай холбоотой дээрх журмыг шинэчлэн батлуулах зайлшгүй шаардлагатай тулгарсан тул УНТЭ-ийн сонгон шалгаруулалтын журмыг шинэчлэн боловсруулж төслийг эмнэлгийн 2025.08.21-ний өдрийн 1/1236 дугаартай албан бичгээр Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлсэн болно.



УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 06 сарын 30 өдөр Дугаар 11 Улаанбаатар хот

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн
Удирдах ажилтан, ажилтан сонгон
шалгаруулах журам батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.10.6 дахь заалт, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Удирдах ажилтан, ажилтан сонгон шалгаруулах журмыг хавсралтаар батлсугай.

2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжилтийг хангаж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирал /Т.Мөнхсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА Д.НАРАНТУЯА



Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын 2020 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн 11 дугаар тогтоолын хавсралт

**Улсын нэгдүгээр төв эмнэлгийн**
**Удирдах ажилтан, ажилтан сонгон шалгаруулах журам**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Монгол улсын "Хөдөлмөрийн тухай хууль", "Төрийн албаны тухай хууль", Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн дэд захирал болон нэгжийн удирдлагыг сонгон шалгаруулах" журам, Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын холбогдох заалтуудыг үндэслэн ажилтанг сонгон шалгаруулж, ажилд авах харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү журмын зорилго нь Улсын нэгдүгээр төв эмнэлэгт мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, хандлагатай ажилтанг сонгон шалгаруулж, чадахуйн зарчим /мерит/-ыг хэрэгжүүлэхэд оршино.

**Хоёр. Сонгон шалгаруулахад баримтлах зарчим**

2.1 Сонгон шалгаруулж ажилд авахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

2.1.1 Ил тод байх
2.1.2 Эрх тэгш байх
2.1.3 Шударга ёсыг хангах
2.1.4 Хараат бус байх
2.1.5 Нууцыг чандлан хадгалах
2.1.6 Шударга өрсөлдөөний зарчмыг баримтлах

Зураг 1. ТУЗ-ийн 11 тоот тогтоол нүүр, хавсралт

*УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн алба нь сул ажлын байрыг:*

1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн - HR.HDC.GOV.MN сайт
2. Монголын ажлын байрны төв сүлжээ - WWW.ZANGIA.MN сайт
3. Эмнэлгийн гадаад цахим вэб хуудас - http://unte.moh.gov.mn/ сайт
4. Хөдөлмөр халамж үйлчилгээний - WWW.EJOB.GOV.MN сайт
5. Монголын худалгаа, үйлчилгээний төв сайт – UNEGUI.MN сайт
6. Эмнэлгийн гадаад нээлттэй фасебүүк сошиал маркетинг пэйж хуудас "УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ/THE FIRST CENTRAL HOSPITAL OF MONGOLIA"
7. Эмнэлгийн хамт олны хаалттай фасебүүк групп
8. Хөдөлмөрийн үзэсгэлэн яармаг
9. Их Дээд сургуулиуд дээр зохион байгуулагддаг өдөрлөг дээр нээлттэй, ил тод зарлаж мэдээллэдэг.
10. Мөн Захиргаа, хүний нөөцийн албанд бүртгэгдсэн хүний нөөцийн сангаас бүрдүүлэлт хийж сонгон шалгаруулалтад оролцогчдыг урьж оролцуулдаг.

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь 2025 оны 12-р сарын 03-ний өдрийн байдлаар **65** ажлын зарыг боловсруулж ил тод, нээлттэй зарлан мэдээллэж ажилласан байна. Үүнд:

УНТЭ-ээс зарласан сул ажлын байр, зарын тоон мэдээлэл

Хүснэгт №1

| № | Зарын огноо | Зарласан сул ажлын байр |
|---|---|---|
| 1 | 2025.01.09 | Лабораторийн техникч |
| 2 | 2025.01.09 | Мэдрэлийн мэс заслын их эмч |
| 3 | 2025.01.09 | Техникийн албаны эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер |
| 4 | 2025.01.09 | Хүний нөөцийн менежер |
| 5 | 2025.01.15 | Хэвтэлт гаргалт хариуцсан бага эмч |
| 6 | 2025.01.19 | Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн |
| 7 | 2025.02.07 | Мэдээлэл технологийн албаны сүлжээний администратор |
| 8 | 2025.02.11 | Лабораторийн техникч |
| 9 | 2025.02.11 | Ариутгагч |
| 10 | 2025.02.19 | Үйлчлэгч |
| 11 | 2025.02.19 | Эм зүйч |

| | | |
|---|---|---|
| 12 | 2025.02.19 | Мэдээлэл технологийн албаны инженер |
| 13 | 2025.03.11 | Лабораторийн техникч |
| 14 | 2025.03.11 | Үйлчлэгч |
| 15 | 2025.03.13 | Эдийн засагч |
| 16 | 2025.03.13 | Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн |
| 17 | 2025.03.31 | Санхүүгийн дотоод аудитор |
| 18 | 2025.04.03 | Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн |
| 19 | 2025.04.08 | Эм зүйч |
| 20 | 2025.04.08 | Мэдээлэл технологийн албаны инженер |
| 21 | 2025.04.22 | Лабораторийн техникч |
| 22 | 2025.04.22 | Ариутгагч |
| 23 | 2025.04.28 | Туслах сувилагч |
| 24 | 2025.04.29 | Нягтлан бодогч |
| 25 | 2025.05.12 | Мужаан |
| 26 | 2025.05.14 | Мужаан |
| 27 | 2025.05.16 | Хуулийн зөвлөх |
| 28 | 2025.05.23 | Аюулгүй байдал, эрсдэл хариуцсан менежер |
| 29 | 2025.05.23 | Харуул хамгаалалтын ажилтан |
| 30 | 2025.05.30 | Эдийн засагч |
| 31 | 2025.06.02 | Үйлчлэгч |
| 32 | 2025.06.02 | ХАБЭА ажилтан |
| 33 | 2025.06.02 | Хөдөлмөр засалч |
| 34 | 2025.06.03 | Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн |
| 35 | 2025.06.19 | Цахилгаанчин |
| 36 | 2025.06.19 | Аюулгүй байдал, эрсдэл хариуцсан менежер |
| 37 | 2025.07.07 | Ариутгагч |
| 38 | 2025.08.14 | ЭМТҮ-ний Чанар, аюулгүй байдлын албаны дарга |
| 39 | 2025.08.15 | Ариутгагч |
| 40 | 2025.08.15 | Хоол зүйч |
| 41 | 2025.08.15 | Цахилгаанчин |
| 42 | 2025.08.15 | Эм зүйч |
| 43 | 2025.08.20 | Хөдөлмөр засалч |
| 44 | 2025.08.20 | Цахим бүртгэгч |
| 45 | 2025.08.22 | Мэдээлэл технологийн албаны инженер |

| | | |
|---|---|---|
| 46 | 2025.08.25 | Техникийн албаны эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер |
| 47 | 2025.09.15 | Туслах сувилагч |
| 48 | 2025.09.19 | МТА-ны техник хангамжийн инженер |
| 49 | 2025.09.19 | Техникийн албаны эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер |
| 50 | 2025.09.19 | Цахим бүртгэгч |
| 51 | 2025.09.26 | Мэдээлэл технологийн албанд сүлжээний болон техник хангамжийн техникч |
| 52 | 2025.09.26 | Цахилгаанчин |
| 53 | 2025.09.26 | Чанарын менежер |
| 54 | 2025.10.08 | Яаралтай тусламжийн их эмч |
| 55 | 2025.10.10 | Жижүүр |
| 56 | 2025.10.28 | Бүртгэгч, зохион байгуулагч |
| 57 | 2025.10.28 | Үйлчлэгч |
| 58 | 2025.10.29 | Дүрслэл оношлогооны төвийн дарга |
| 59 | 2025.10.29 | Техникийн албаны эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер |
| 60 | 2025.10.30 | Зүрхний төвийн дарга |
| 61 | 2025.10.30 | Цахилгаанчин |
| 62 | 2025.11.03 | Туслах сувилагч |
| 63 | 2025.11.04 | Ариутгагч |
| 64 | 2025.12.03 | Инженерийн байгууламжийн албаны дарга |
| 65 | 2025.11.19 | Мэдээлэл технологийн албаны сүлжээ, холбооны инженер |

## 1.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН СИСТЕМД СУЛ АЖЛЫН БАЙРНЫ ЗАРЫГ МЭДЭЭЛЛЭСЭН БАЙДАЛ

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эрүүл мэндийн салбарын нийт ажилчдыг хамарсан сургалт, хөгжлийн хүний нөөцийн систем 2022.03.01-ний өдрөөс эхлэн амжилттай нэвтэрч ажиллаж байна. УНТЭ-ийн хүний нөөцийн менежерүүд нь уг системд тусгай нэвтрэх, нууц үгээр нэвтрэх бөгөөд тус системд сул ажлын байрны зарыг оруулах эрхтэй. Уг системд эмнэлгийн мэргэжилтний сул ажлын байрны зарыг оруулж мэдээллэсэн байна. Үүнд: эмзүйч, лабораторийн техникч, дүрс оношлогооны техникч, чанарын менежер, сувилагч, туслах сувилагч, ариутгагч, Зүрхний төвийн дарга, Дүрс оношлогооны төвийн дарга, яаралтай тусламжийн их эмч, хөдөлмөр засалч



Зураг 2. УНТЭ-ээс ЭМХТ-ийн hr.hdc.gov.mn хүний нөөцийн сургалт, хөгжлийн системд зарласан сул ажлын байр, зарын мэдээлэл

## 1.2. МОНГОЛЫН АЖЛЫН БАЙРНЫ ТӨВ СҮЛЖЭЭ - WWW.ZANGIA.MN САЙТАНД СУЛ АЖЛЫН БАЙРНЫ ЗАРЫГ МЭДЭЭЛЛЭСЭН БАЙДАЛ

Зангиа портал ХХК-тай “Зар сурталчилгааны үйлчилгээ үзүүлэх” мөнгөн гишүүний эрхтэй хэрэглэгчийн хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. УНТЭ нь 2025.12.03-ны өдрийн байдлаар zangia.mn сайтад **18** ажлын байрны зарыг оруулж ил тод, нээлттэй зарласан.

Уг сайтад зарлагдсан ажлын байрны зарууд нийтдээ 11339 хандалтууд авч, 5962 ажил горилогч цахимаар анкетаа илгээсэн үзүүлэлттэй байна.



Зураг 3. УНТЭ-ээс ЭМХТ-ийн zangia.mn зарласан сул ажлын байр, зарын жагсаалт

### 1.3. УНТЭ-ИЙН ГАДААД ЦАХИМ ХУУДАС - UNTE.MOH.GOV.MN САЙТАНД СУЛ АЖЛЫН БАЙРНЫ ЗАРЫГ МЭДЭЭЛЛЭСЭН БАЙДАЛ

Байгууллагын гадаад сайтны нээлттэй ажлын байр буланд 2025.12.03-ны өдрийн байдлаар нийт 65 ажлын байрны зарыг ил тод байршуулж мэдээллэсэн.




Зураг 4. unte.gov.mn дээр байршуулсан сул ажлын байрны зарууд

## 1.4. ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ - WWW.EJOB.GOV.MN САЙТАНД СУЛ АЖЛЫН БАЙРНЫ ЗАРЫГ МЭДЭЭЛЛЭСЭН БАЙДАЛ

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын мэргэжилтэнтэй 2023.03.14-ний өдөр холбогдон системд ажил олгогч эрхээр бүртгэл үүсгэн ашиглаж байна. 2025.12.03-ны өдрийн байдлаар нийт 35 ажлын байрны зарыг ejob.gov.mn системд бүртгэн ил тод нээлттэй зарласан.




Зураг 5. ejob.gov.mn дээр байршуулсан сул ажлын байрны зарууд

## 1.5 МОНГОЛЫН ХУДАЛГАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ САЙТ – UNEGUI.MN САЙТ

Ажлын горилогчийн анкет бага ирэх болон огт ирэхгүй тохиолдолд үүсэж буй зарим албан тушаалын ажлын зарыг илүү олон хүнд хүргэх зорилгоор unegui.mn сайд байршуулсан.

**UNEGUI.MN** Монголын худалдааны төв сайт Zar

Бүх зарууд > Ажлын зар > Үйлчилгээ > Цэвэрлэгээний ажилтан

## Үйлчлэгч

УБ — Сүхбаатар, Сүхбаатар, Хороо 1
Нийтэлсэн: 2025-11-11 14:12 Зарын дугаар: 9892617

Зарлагч: **Байгууллага**  Ажлын цаг: **Бүтэн цагийн**

Туршлага: **Шаардлагагүй**  Мэргэжлийн түвшин: **Анхан шатны**

**Байршил:** Улаанбаатар — Сүхбаатар — 1-р хороо




Улсын эмнэлэгт үйлчлэгч ажилд авна.

Зураг 6.unegui.mn дээр байршуулсан сул ажлын байрны зарын жишээ

### 1.7 УНТЭ-ИЙН НЭЭЛТТЭЙ ФАСЕБҮҮК СОШИАЛ МАРКЕТИНГ ПЭЙЖ ХУУДАСТ/УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ/THE FIRST CENTRAL HOSPITAL OF MONGOLIA

Эмнэлгийн гадаад нээлттэй фасебүүк сошиал маркетинг пэйж хуудаст 2025.12.01-ний өдрийн байдлаар нийт **65** сул ажлын байрны зарыг нээлттэй, ил тод зарлаж байршуулсан байна.




Зураг 7. Эмнэлгийн гадаад нээлттэй фасебүүк сошиал маркетинг пэйж хуудас дээр байршуулсан сул ажлын байрны зарууд

## 1.8 УНТЭ-ИЙН ЭМНЭЛГИЙН ДОТООД E-HEALTH СИСТЕМД СУЛ АЖЛЫН БАЙРНЫ ЗАРЫГ МЭДЭЭЛЛЭСЭН БАЙДАЛ



Зураг 6. Эмнэлгийн дотоод ehealth программ дээр байршуулсан сул ажлын байрны зарууд

## 1.6. УНТЭ-ИЙН ЭМНЭЛГИЙН ХАМТ ОЛНЫ ХААЛТТАЙ ФАСЕБҮҮК

Эмнэлгийн хамт олны хаалттай фасебүүк групп, E-health системд 2025.12.03-ны өдрийн байдлаар дотооддоо 10 сул ажлын байрыг нээлттэй, ил тод байршуулж ажилласан.




Зураг 6. Эмнэлгийн дотоод хаалттай фасебүүк сошиал маркетинг пэйж хуудас дээр байршуулсан сул ажлын байрны зарууд

## 1.7. АНАГААХ УХААНЫ ИХ ДЭЭД СУРГУУЛИУД БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ЯАРМАГ ДЭЭР ОЧИЖ АЖИЛЛАСАН МЭДЭЭЛЭЛ

УНТЭ-ийн Сувилахуйн алба, Захиргаа хүний нөөцийн албатай хамтран ажил олгогчийн уулзалтад 4 удаа оролцож нийт 147 төгсөх дамжааны оюутныг бүртгэн ажилласан. Үүнд:

1. 2025.04.10 - Этүгэн их сургууль – 42 оюутан
2. 2025.05.01 - АШУҮИС Сувилахуйн сургууль – 68
3. 2025.05.02 - Дархан –Уул аймаг Сувилахуйн сургууль – 29 оюутан
4. 2025.05.16 – АШУҮИС ажил олгогчдын нэгдсэн уулзалт - 8 оюутныг тус тус бүртгэн

эмнэлгийн танилцуулга материалыг тарааж их дээд сургуулиудтай хамтран ажилласан.




Зураг 3. Ажил олгогчийн өдөрлөгийн үеэр




Зураг 4. Ажил олгогчдын уулзалтад бэлтгэсэн боршур, танилцуулга

| | |
|---|---|
| Боловсруулсан: | Б.Энхбилиг |
| Хянасан: | Ч.Бямбасүрэн |
| Хувь: ...1...... | |